



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 280

Улаанбаатар хот

“Миг даатгал” ХХК-д дүрмийн сан
/хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээндээ
өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3 Даатгалын тухай хуулийн 21.3.2, 21.5, 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 333 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Миг даатгал” ХХК-ийн дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээг “Миг даатгал” ХХК-ийн 2012 оны I хагас жилийн хуримтлагдсан ашгаас нийт 224,000,000.0 /хоёр зуун хорин дөрвөн сая/ төгрөгөөр нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

№	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Нэмэлт хөрөнгө оруулалт	Эцсийн үлдэгдэл	
1	Д.Зоригт	621,600,000.0	78,400,000.0	700,000,000.0	35%
2	Ж.Бат-орших	248,640,000.0	31,360,000.0	280,000,000.0	14%
3	У.Бямбасүрэн	195,360,000.0	24,640,000.0	220,000,000.0	11%
4	Х.Ганбаатар	195,360,000.0	24,640,000.0	220,000,000.0	11%
5	Хадгаламж банк	177,600,000.0	22,400,000.0	200,000,000.0	10%
6	Н.Энхболд	142,080,000.0	17,920,000.0	160,000,000.0	8%
7	Г.Батбаяр	88,800,000.0	11,200,000.0	100,000,000.0	5%
8	Г.Лхамсүрэн	71,040,000.0	8,960,000.0	80,000,000.0	4%
9	Л.Цэцэг-Эрдэнэ	35,520,000.0	4,480,000.0	40,000,000.0	2%
	Нийт	1,776,000,000.0	224,000,000.0	2,000,000,000.0	100.0%

2. Дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2012 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Миг даатгал” ХХК /Ж.Бат-орших/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН